



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/285

Сүхбаатар сум

### Түр хязгаарлалт тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "ж", Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1, 69.1.2, 69.1.3, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал хураалт явагдахтай холбогдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 08.00 цагаас эхлэн 10 дугаар сарын 17-ны өдрийн 10.00 цаг хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2. Сонгуулийн санал авах 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Соёл, урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвийг ажиллуулахыг хориглосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ